



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 25. өдөр

Дугаар A/995

Мандалговь

Гоц халдварт шүлхий, бог малын мянган
өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга
хэмжээг чангатгаж өндөржүүлсэн бэлэн
байдалд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3 "а", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 5,6 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4, 11.3.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.8.1, 9.8.2, 13 дугаар зүйлийн 13.3, 15, 16-р зүйл, 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.2, 17.3, 19 дүгээр зүйлийн 20.1.2-оос бусад зүйл, 31 дүгээр зүйлийн 31.1, 34 дүгээр зүйлийн 34.2.2.1, 36 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэдалай, Адаацаг, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Луус, Хулд, Дэлгэрцогт, Цагаандэлгэр, Сайнцагаан сумдад гоц халдварт шүлхий, Өлзийт, Дэлгэрхангай сумдад гоц халдварт бог малын мянган өвчин тус тус бүртгэгдэж Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хийсэн шинжилгээгээр онош батлагдсан тул 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэл аймгийн Онцгой комисс, төрийн болон аж ахуй нэгж байгууллага, гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг бүрэн дайчилж гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллуулсугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шүлхий, бог малын мянган өвчиний халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдвартгүйтгэх, дархлаажуулах, хорио цээрийн дэглэмийг хатуу мөрдөж дараах үйл ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 1-ны өдөр хүртэл зохион байгуулахыг сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

2.1 Аймгийн нутаг дэвсгэрт гадны аймгаас отор нүүдэл, үржлийн зориулалтаар малын шилжилт хөдөлгөөн оруулахгүй байх. Өөрийн аймгийн зөвхөн отроор ирж байгаа малчин өрхийг малын эмчийн үзлэг, асуумж, багийн даргын зөвшөөрлөөр нэвтрүүлж өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг бууруулах хугацаа хүртэл аймаг дотор шилжилт хөдөлгөөн хийлгэхгүй байх.

2.2 Өөрийн аймгийн сум хооронд отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн хийлгэхгүй байх.

2.3 Морин уралдаан, малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулахгүй байх.

2.4 Голомттой сумдаас амьд мал зах зээлд нийлүүлэхгүй байх, зөвхөн эрүүл сууриас малыг нядалж мал эмнэлгийн хяналт зөвшөөрлөөр төхөөрч зах зээлд нийлүүлэх, аймаг сумын мал нядалгааны цэгт байнгын хяналт, халдвартгүйтгэл хийлгэж байх.

2.5 Шүлхий, бог малын мянгангийн халдварт бүртгэгдсэн сумд тус өвчнүүдтэй тэмцэх заавар, хорио цээр тогтоох журам зэргийг ягштал мөрдөж халдвартын хүрээг тархвар зүйн асуумж судалгаа, зураглалд үндэслэн тогтоож голомт болон

48191b974

постны үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн анги болон малчдын оролцоо, сахилга батыг хангулан ажиллуулах.

2.6 Халдвар бүртгэгдээгүй эрүүл бүс болон дархлаажуулалтад хамрагдсан сумд халдвар илрүүлэх тандалт судалгааг тогтмол хийж, төв суурин газрын иргэд онц шаардлагагүй бол халдвар бүртгэгдсэн сумуудруу зорчихгүй, хөдөө айлд очихгүй байхыг анхааруулах.

2.7 Бог малын мялзан өвчний яаралтай дархлаажуулалт зохион байгуулах үед малчдыг товлосон цагт мал сүргээ бэлэн байлгах, тарилгын хашаа, хүн хүч зэргийг бэлэн байлгаж малын эмчийг аюулгүй, чанартай, богино хугацаанд дархлаажуулалт хийх нөхцөлийг хангуллах.

2.8 Өвчлөлийн талаарх мэдээллийг өдөр бүр аймгийн мал эмнэлгийн газар, онцгой комиссын шуурхай штабт мэдээлэх.

3. Яаралтай дархлаажуулалтад хамрагдах малын тоог нэг дүгээр, сумдад олгох зардлыг хоёр дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед мөрдөх холбогдох хууль, заавар, журмын хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), мал эмнэлгийн төрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), захирамжийн хэрэгжилтийг хангуйж тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир) нарт үүрэг болгосугай.

5. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан сумын онцгой комиссыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (М.Адъяабаатар) –т даалгасугай.

6. Сумын нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын болон орон нутгийн чанартай авто замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбат)-д даалгасугай.

7. Өвчин гарсан сумдын хорио цээрийн дэглэмийн үеийн зардалд 27780790 (хорин долоон сая долоон зуун наян мянга долоон зуун ерэн төгрөг)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ

